



## УУРХАЙН БҮСЭД ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ, ӨӨРЧЛӨХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“Эрдэнэс-Тавантолгой” ХК /цаашид “ЭТТ” ХК гэх/-ийн Уурхайн бүсэд замын хөдөлгөөнийг зохицуулах, аюулгүй байдлыг хангуулах болон түүний чиглэлд өөрчлөлт хийх, шинээр зам тавихтай холбоотой харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журам “ЭТТ” ХК-ийн уурхайн болон уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт болон туслан гүйцэтгэгч компани, тэдгээрийн ажилтанд нэгэн адил хамааран үйлчилнэ.

1.3.Энэхүү журамд тусгагдаагүй асуудал нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, ажлын горим, заавраар шийдвэрлэгдэнэ.

1.4. Аливаа хөдлөх машин, тоног төхөөрөмж /цаашид тээврийн хэрэгсэл гэх/-ийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах хязгаарлах зорилгоор хийсэн замын хаалт, хөвөө болгон Хамгаалалтын далан байгуулна.

1.5.Хуучин замын хөдөлгөөнийг эсрэг болон нэг чигийн хөдөлгөөний урсгалтай болгох, эсхүл чиглэлийг нь бүх мөсөн өөрчлөх, уулзвар шинээр нээх, хаах, шинээр зам тавих зэргээр замын хөдөлгөөний өөрчлөлтийг хийнэ.

### Хоёр. Уурхайн бүсийн замын хөдлөгөөнд оролцох, ажиллах техникийн бэлэн байдал

2.1. Замын хөдлөгөөнд оролцох, ажиллах тээврийн хэрэгсэл дор дурдсан ерөнхий шаардлага тавигдана.

2.1.1.Уурхайн бүсэд ажиллах тээврийн хэрэгсэл нь зохих ёсоор бүртгэгдсэн, техникийн улсын үзлэгт орж тэнцсэн байх;

2.1.2.Засвар үйлчилгээг чанарын шаардлага хангахуйц хэмжээнд хийсэн байх;

2.1.3.Тойрох үзлэгийн хуудастай байх;

2.1.4.Бага оврын суудлын автомашин нь зөв талдаа жолооны хүрдтэй, үзэгдэх байдлыг сайжруулах зорилгоор цагаан<sup>1</sup> өнгөтэй, нь дөрвөн дугуйндаа хөтлөгчтэй байх;

2.1.5.Стандарт шаардлага хангасан галын хортой (2-6кг) байх;

2.1.6.Стандартын шаардлага хангасан, ямар нэгэн гэмтэлгүй өндрийн тугтай байна. Нийт өндөр нь газраас 4м-ээс багагүй байна. Дарцаг нь 40х40см-ээс багагүй

<sup>1</sup> Компани цаашид үзэгдэх байдлыг нь харгалзан зөвхөн “ЦАГААН” өнгийн машиныг уурхайд нэвтрүүлэх, одоо явж байгаа “БАРААН” өнгийн машинуудыг аажмаар хасах бодлого баримтална.

хэмжээтэй, амархан нугарч унжихгүй, хатуу материалаар хийгдсэн, гэрэл ойлгогч тууз бүхий тод шар, улбар шар, улаан өнгөтэй байх;

2.1.7.Тээврийн хэрэгсэлийн бүх талаас ил харагдах газар байрлуулсан маягтай байна. Маяк нь линзний диаметрээрээ 12см-ээс багагүй, өндөр нь 15см-ээс багагүй, гэрэлтэх чадвар нь хангалттай тод байх;

2.1.8.Суудал нь заавал урагшаа харсан<sup>2</sup> байрлалтай байх;

2.1.9.Уурхайн бүсэд ажиллах бүх тээврийн хэрэгсэл паркын дугаартай байх бөгөөд уг лугаарыг наах талбай байхгүй тохиолдолд кабины орой дээр нь 3-н тал руугаа харсан байдлаар хар дэвсгэр дээр гэрэлтдэг шар хуулгаар хийсэн байх;

2.1.10.Радио станцаар тоноглогдсон байх;

2.1.11.Арын гэрлүүдийг уурхайн нөхцөлд тохируулан бүхээгний дээр түвшинд байрлуулах;

2.1.12.Суудлын автомашин нь 2 талдаа туушид нь өргөн нь 50-75мм, урт нь 200мм-ээс багагүй хэмжээтэй гэрэл ойлгогч шар өнгийн хуулга наасан байх;

2.1.13.Автогрейдер, бульдозер, автосамосвал зэрэг хүнд машин механизмын хувьд 80 мм-ээс багагүй өргөнтэй гэрэлтдэг хуулгыг тухайн техникийн овор хэмжээг харуулах байдлаар наасан байх;

2.1.14.Дугуйт ачигч, автосамосвал, механизмууд нь ардаа зай буюу хөдөлгөөн мэдрэгч, ухрахын дуут дохиотой байх;

2.1.14.Эмнэлгийн тусламж үзүүлэх болон осол гарсан үед ажиллах автомашиныг тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглох, эдгээр автомашины жолооч тусгай сургалт, зааварчилгаанд хамрагдсан байх зэрэг болно.

### **Гурав. Замын хөдөлгөөнд оролцох**

3.1.Уурхайн бүсэд замын хөдөлгөөнд оролцох бүх жолооч, операторууд Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

3.2.Жолооч, оператор нь эрүүл мэндийн үзлэгээр орж тэнцсэн, зохих сургалтанд хамрагдсан, ангилалын үнэмлэх, гэрчилгээтэй, насанд хүрсэн хүн байна.

3.3.Ажилд гарах гэж буй жолооч хоногт 8 цагаас багагүй хугацаанд сайн унтаж, амарсан байна.

3.4.Жолооч ажил эхлэхийн өмнө хариуцсан тээврийн хэрэгсэлдээ тойрох үзлэгийг чанартай хийж, гүйцэтгэсэн байна.

3.5.Автомашин, техникт суух, буухдаа “3 цэгийн дүрэм”-ийг баримтална.

3.6.Жолооч зөвхөн уурхайн үнэмлэхтэйгаар хязгаарлагдсан бүсэд /улаан, шар, ногоон/ зорчино.

3.7.Технологийн замаар нэвтрэх болон “улаан” бүс рүү нэвтрэх тохиолдолд тухайн талбайг хариуцсан мастераас зөвшөөрөл авна.

3.8. Жолооч цаг агаар болон орчны нөхцлөөс хамааран замын нөхцөл байдалд тохируулж тээврийн хэрэгсэлийг жолоодно.

### **Дөрөв. Дуут дохио**

4.1. Уурхайн бүсэд ажиллаж байгаа бүх тээврийн хэрэгсэл дараах дуут дохионы дүрмийг баримтална.

4.1.1. Нэг удаа + 5 секунд хүлээгээд<sup>3</sup> хөдөлгүүрийг асаана.

4.1.2. Хоёр удаа + 5 секунд хүлээгээд урагш хөдлөнө.

4.1.3. Гурван удаа + 5 секунд хүлээгээд ухрах үйлдэл хийнэ.

### **Тав. Хөдөлгөөнд оролцоход анхаарах зүйл**

5.1. Хөдлөгөөнд оролцоход дор дурдсан зарчмыг баримтлан ажиллана.

5.1.2. Автосамосвалын араас явж байгаа тээврийн хэрэгсэл хамгийн багадаа 30м-ээс багагүй буюу 3 машины зай барьж явна. Хэрэв замын нөхцөл муу бол 50м-ээс хол зай барина.

5.1.3. Зөвхөн ачуулах эсхүл буулгах автосамосвал л экскаваторын “ажлын тойрог” буюу 50 метрийн радиус болон авто ачигч, бульдозерын маневрын зайд нэвтрэнэ.

5.1.4. Хөнгөн тэрэг болон явган хүн зөвхөн операторын зөвшөөрлөөр хүнд механизмын ажлын бүс буюу 50м радиуст орж болох бөгөөд тухайн техникийн харьцах эд ангийг газарт бүрэн буулгаж, хөдөлгөөнгүй зогссоны дараа ажлын бүсэд орно.

5.1.5. Уурхайн бүсэд тээврийн хэрэгсэл эвдэрч, зогссон тохиолдолд тухайн машин механизмын оператор, жолооч нь тэр дор нь мастер болон бусад ойр ажиллаж байгаа техникүүдийн операторт мэдээлж аюулгүй байдлын арга хэмжээг яаралтай авах үүргийг хүлээнэ.

5.1.6. Хаалт, хязгаарлалт хийсэн, орохыг хориглосон бүс рүү ямар ч тохиолдолд нэвтрэхийг хориглоно.

5.1.7. Ямар ч тохиолдолд араа (авцуулах холбоо) салгахыг хориглоно.

5.1.8. Авто ачигч, автогрейдер, бульдозер нь хөдөлгөөнд оролцохдоо харьцах эд ангиа газраас 0.5-1м зайд өргөсөн байдлаар явна.

5.1.9. Автосамосвал хөдөлгөөнд оролцох үедээ тэвшээ буулгасан байх ёстой бөгөөд өдөр, шөнийн аль ч цагт оврын гэрлээ асааж явна.

5.1.10. Зориулалтын бус ачаа ачих, хазгай талбайд тэвшээ өргөх, зогсоолын тормоз таталгүй зогсох, кабинд зөвшөөрөлгүй хүн суулгах, маршрутын бус замаар явах, буулгах цэгээс өөр газар ачаа буулгах зэрэг дүрмэнд заагдаагүй ажил, үйлдэл гүйцэтгэхийг хатуу хориглоно.

5.1.11. Оператор, жолооч нар нь хоолны завсарлага болон бусад шалтгаанаар зогсох үедээ карьерийн мөргөцөгийн хананаас аюулгүй зайд, эсвэл зогсоолын талбайд машин техникээ зохих журмаар нь ухрааж байрлуулна.

5.1.12.Шатахуун, түлш олгох зориулалтын цэгээс цэнэглэлт хийхдээ суудлын машины хоорондын зай 2м, ачааны машины хоорондын зай 4м-ээс багагүй байх дарааллын журмыг баримталж ажиллана.

5.1.13.Кабинаасаа буусан тохиолдолд эргэн тойрны болон ойртон ирж байгаа техникийн оператортой холбоо барьж өөрийгээ байгаа гэдгийг мэдэгдэнэ.

### **Зургаа. Хөдөлгөөнд оролцоход хориглох зүйл**

6.1.Хөдлөгөөнд оролцох үед дор дурдсан зүйлийг хориглоно.

6.1.1.Хөнгөн тэрэг нь технологийн тээврийн хэрэгслийн аюулгүй зай буюу 50м-ээс дотогш тухайн хэрэгслийн операторын зөвшөөрөлгүй орохыг;

6.1.2.Хөнгөн тэрэгний жолооч сохор талаар зэрэгцэж явахыг;

6.1.3.Хөнгөн тэрэгний жолооч хүнд машин, механизмын өмнө болон ард зогсохыг;

6.1.4.Сургалтын үнэлгээ хийхээс бусад тохиолдолд авто ачигч, автогрейдер, бульдозер, экскаватор зэрэг хүнд механизмд зөвшөөрөлгүй хүн суулгахыг;

6.1.5.Уурхайн бүсэд тээврийн хэрэгсэл эвдэрч, зогссон тохиолдолд тухайн машин механизмын оператор, жолооч нь тэр дор нь мастер болон бусад ойр ажиллаж байгаа техникүүдийн операторт мэдээлж аюулгүй байдлын арга хэмжээг заавал авна. Мэдээлэхгүй дур мэдэж үйл ажиллагаа явуулахыг;

6.1.6.Хаалт, хязгаарлалт хийсэн, орохыг хориглосон бүс рүү ямар ч тохиолдолд нэвтрэхийг;

6.1.7.Маршрутын бус замаар явах, буулгах цэгээс өөр газар ачаа буулгах зэрэг дүрмэнд заагдаагүй ажил, үйлдэл гүйцэтгэхийг;

6.1.8.Рамп болон үзэгдэх орчин хязгаарлагдмал газар буцаж эргэх үйлдэл хийхийг хориглоно.;

6.1.9.Өрөмдлөг тэсэлгээний талбайд тэсэлгээний асуудал хариуцсан мастераас зөвшөөрөл авалгүй нэвтрэхийг тус тус хориглоно.

6.2.Жолооч уурхайн бүсэд зориулалтын зогсоолоос бусад хэсэгт тээврийн хэрэгслээ орхиж буух шаардлага гарсан тохиолдолд аюулгүйн зай авч, аюулгүй байдлаа бүрэн хангаж бууна.

### **Долоо. Уурхайн бүсэд ачаа тээвэрлэх**

7.1.Жолооч уурхайн бүсэд ачаа тээвэрлэхдээ дор дурдсан зүйлийг мөрдлөгө болгоно.

7.1.1. МУ-ын замын хөдөлгөөний дүрмийг мөрдлөг болгож ажиллах;

7.1.2. Жолоочийн харах орчин хязгаарлагдаагүй, хөдөлгөөнд оролцох үед ачаа нь унаж чирэгдэж аюул учруулахааргүй байлгах;

7.1.3. Тээврийн хэрэгслийн тогтворжуулалт алдагдахаар ачааг өндөрлөхгүй, даац хэтрүүлэхгүй байлгах;

7.1.4. Тэсэрч дэлбэрэх, амархан шатах болон бусад аюултай ачааг даацын 2/3-оос хэтрүүлээгүй, тэвш нь мод, резинэн материалаар хийгдсэн буюу хөндийрүүлэгдсэн, янданд нь оч дарагч тавигдсан, улаан дарцагболон гэрлэн дохиогоор тоноглогдсон, тусгай тэмдэг тэмдэглэгээ тавигдсан, тэсрэх бодис, хэрэгсэлийг тусад нь хайрцаглаж савласан байх зэрэг болно.

### **Найм. Хөдөлгөөний давуу эрх**

8.1. Жолооч уулзварт нэвтрэхдээ замын нөхцөл байдлыг зөв үнэлж, замын нөхцөлд тохируулан тээврийн хэрэгслийг жолоодно.

8.2. Уурхайн замын бүх уулзвар хэсгүүдэд замын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан байх бөгөөд бүх тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээний дагуу хөдөлгөөнд оролцоно.

8.3. Хэрэв тэмдэг, тэмдэглэгээ байхгүй бол зорчиж байгаа тээврийн хэрэгсэл дараах байдлаар энэ тэргүүнд зам тавьж өгөх үүрэг хүлээнэ.

8.3.1. Онцгой тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх шаардлагаар аваарын дохио асаасан эмнэлэгийн болон галын машинд;

8.3.2. Тэсэлгээний машинд; /Ингэхдээ гэрэл дохио асааж хурдаа тохируулан зорчих бөгөөд заавал гүперлүүлж явна/

8.3.3. Ачаатай тээврийн хэрэгсэлд;

8.3.4. Ижил хэмжээ, даацтай автосамосвал нэг зам ашиглаж байгаад нөхцөлд өгсөж байгаа автосамосвалд зэрэг болно.

8.4. Хоёр өөр түвшингээс ачилт хийх үед өгсүүр рамп дээр уулзварт зэрэг нэвтрэх бол "сохор" талд байрлалтай дампыг нь нөгөөдөө зам тавьж өгнө. /Учир нь дүрмээр зам тавьж өгөх ёстой автосамосвал нь сохор талаасаа зэрэгцэн ирэх дампыг харахгүй байх магадлалтай байдаг/

8.5. Аливаа машин механизмын жолооч (оператор) уулзварт зэрэг орж ирсэн тохиолдолд баруун гар талын машиндаа зам тавьж өгнө.

8.6. Технологийн замд хутгаа буулган ажиллаж байгаа дозер, автогрейдер болон усалгаа хийж буй усны машин давуу эрхтэй байна. Хэрэв эдгээр нь технологийн замаар ажлын талбар хооронд зорчиж байгаа бол автосамосвал давуу эрх эдэлнэ.

8.7. Суудлын тэрэгнүүд бүх техникт зам тавьж өгнө.

### **Ес. Гүйцэж түрүүлэх**

9.1. Суудлын автомашин болон автосамосвалын хөдөлгөөнийг аль болох тусгаарласан байхаар уурхайн замын сүлжээг төлөвлөнө.

9.2. Гинжит техникийн нүүдэл хийх үед зам дээр эвдэрсэн техник, зам засаж буй грейдер байвал станцаар холбогдож, харилцаж зөвшөөрөл авч үзэгдэх орчин чөлөөтэй байгаа эсэх, уулзвар, эргэлтгүй байгаа эсэх, зам тэгш, шулуун зам байгаа эсэх, эсрэг урсгал чөлөөтэй байгаа эсэхийг тус тус нягтласны үндсэн дээр гүйцэж түрүүлэх үйлдэл хийж болно.

9.3. Харагдах орчин хязгаарлагдаагүй үед шулуун зам дээр, урд яваа тээврийн хэрэгсэл 20км/ц-аас доош хурдтай яваа тохиолдолд тухайн гүйцэж түрүүлэх гэж байгаа

тээврийн хэрэгслийн оператортай станцаар холбогдож зөвшөөрөл авсны дараа гүйцэж түрүүлж болно. Энэ үйлдлийг зөвхөн бага оврын суудлын автомашинаар хийхийг зөвшөөрнө<sup>4</sup>.

### **Арав. Тээврийн хэрэгсэл, машин механизмыг парклах**

10.1. Уурхайн бүсэд автомашин, хүнд машин механизмыг түр болон удаан хугацаагаар зогсоох тохиолдолд дараах зарчмыг баримтална.

10.1.1. Уулын ээлжийн мастерт мэдэгдэнэ.

10.1.2. Машин эвдрэх мөн бусад шалтгаанаар яаралтай зогсолт хийх шаардлага үүсээгүй тохиолдолд рамп дээр, булан, тойруу газар удаан зогсох, парклахыг хориглоно.

10.1.3. Урагшаа гарч явахад боломжтой, тэгш газрыг сонгож техникийг байрлуулна.

10.1.4. Мөргөцгийн нүүрний өндрийг 2 дахин авснаас дотогш, эсхүл карьерын хананаас 20 метрийн дотор машин парклахыг хориглоно.

10.1.5. Онцгой тохиолдолд, эсвэл эвдрэлийн улмаас автосамосвалыг налуу газар зогсооход хүрвэл оператор нь машинаа орхиж гарахдаа дараах үйлдлийг гүйцэтгэнэ.

- 1) Хаана паркалснаа бусад операторуудад мэдэгдэнэ.
- 2) Дугуйг хана юмуу хөмсөг тийш эргүүлнэ.
- 3) Трансмиссаа нейтральд шилжүүлнэ.
- 4) Зогсоолын тормосоо татна.
- 5) Газрын уруу талд нь дугуйны ивээс хийнэ.
- 6) Аваарын гэрлээ асаана.

10.2. Уруу газар эвдэрч зогссон автосамосвалын урд хатуу хашилт буюу шороо асгаж өнхрөхөөс сэргийлнэ. Мөн тухайн хэсэгт конус байрлуулна.

10.3. Хүнд механизмыг парклахдаа хутга, соёо, шанага зэрэг газартай харьцах эд ангиудыг нь буулгаж парклана.

10.4. Ачаатай автосамосвал эвдэрч рамп дээр удаан хугацаагаар зогсоох бол, ачаагаа бүгдийг нь юмуу талыг нь газрын уруу талдаа асгаж, өнхрөхөөс сэргийлнэ.

10.5. Хоолны цагаар, эсвэл ээлж солих үеэр зогсоолд паркалсан машиныг хөдөлгөхдөө буруу тал руугаа дарж эргэхийг хориглоно.

10.6. Засварын тавцан дээр машиныг байрлуулсаны дараа өнхөрч хөдлөхөөс сэргийлж дугуйны ивүүрийг ивнэ.

10.7. Зогсоолын талбайд машин, механизмыг байрлуулахдаа зориулалтын нүхэн ховилд арын дугуйгаа оруулан ухрааж зогсооно. Зориулалтын ховилгүй талбайд парклах бол дугуйны ивүүр хийнэ.

10.8. Хөнгөн тэрэг зориулалтын тэгш зогсоолын талбайд парклахдаа хөдөлгүүрийг унтрааж, гар тормозоо татсан байна.

10.9. Жолооч үзэгдэх орчин хязгаарлагдсан үед аль болох ухрахаас зайлсхийх үүрэгтэй бөгөөд ухрах бол заавал дохиочин ашиглана.

10.10.Хөнгөн тэргийг уурхайн бүсэд парклах бол хүнд машин, механизмын операторт харагдахаар зөв талд нь, зэрэгцээ байрлалд тавина.

### **Арван нэг. Хурдны хязгаар**

11.1.Жолооч, оператор уурхайн замын хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор тавьсан замын тэмдэг, тэмдэглэгээг байнга дагаж мөрдөнө.

11.2.Уурхай, хотхон, орон нутгийн замд тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаар 60км/ц байна.

11.3.Уурхайн технологийн замд 40км/ц байна.

11.4.Хотхоны орчим, нүүрсний агуулах, ачих, буулгах хэсэгт тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаар 20 км/ц, засварын цех, оффисийн орчимд хурдны хязгаар 10км/ц байна.

11.5.Уурхайн замын хөдөлгөөний журам болон ХАБ-ын зөрчил гаргасан тохиолдолд зөрчлийн төрлөөс үл хамаарч дор дурсан арга хэмжээг авна.

11.5.1.Анх удаа зөрчил гаргасан бол зөрчлийн хуудас бичиж, ХАБ-ын урамшууллын хувиас 5 %-ийг хасч, давтан зааварчилгаанд хамруулна.

11.5.2.Хоёр дахь удаа зөрчсөн бол зөрчлийн хуудас бичиж, ХАБ-ын урамшууллын хувиас 10 %-ийг хасч, давтан зааварчилгаанд хамруулна.

11.5.3.Гурав дахь удаа зөрчсөн бол зөрчлийн хуудас бичиж, ХАБ-ын урамшууллын хувиас 15%-ийг хасч, уурхайд жолоо барих эрхийг хязгаарлана. Энэ хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болно.

### **Арван хоёр. Өөрчлөлтийг төлөвлөх үе шат**

12.1.Замын хөдөлгөөний өөрчлөлт хийх төлөвлөгөөнд тухайн замыг хэрхэн өөрчлөхийг харуулсан зураг, түүний хааж, нээх хугацааг тодорхой тусгасан байна.

12.2.Уурхайн бүсэд шинээр хийгдэх замын хөдөлгөөний өөрчлөлтийн төлөвлөгөөг Уурхайн удирдлага гарын үсэг зурж баталгаажуулна.

12.3.Замын хөдөлгөөнийг нээж хаахтай холбоотой хөдөлгөөн зохицуулалт хийх, шаардлагатай бол төлөвлөлтийн инженер нь тухайн замыг хаахаас 24 цагийн өмнө хэлтэс нэгжийн удирдлагууд, уурхайн болон талбайн мастерууд, хөдөлмөрийн аюулгүй байдал /цаашид "ХАБ" гэх/-ын ажилтнуудаас гадна гэрээт компаниудад мэдэгдсэн байна.

12.4.Замын хөдөлгөөний өөрчлөлтийг төлөвлөхдөө тухайн замын өөрчлөлттэй холбоотой аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай замын хаалт, далан, тэмдэг тэмдэглэгээг бүрэн тусгаж төлөвлөнө.

12.5.Төлөвлөлт хийхдээ компанийн ХАБ хариуцсан нэгжийн санал зөвлөмжийг тусгана.

12.6.Шинээр зам тавих төлөвлөлт хийхдээ "Газар хөндөх зөвшөөрөл" авах шаардлагатай бол Байгаль орчны ажилтанд мэдэгдэж, "Шимт хөрстэй ажиллах журам"-ын дагуу газар хөндөх зөвшөөрөл авсан байна.

12.7.Төлөвлөлтийн ажилтан нь замын хөдөлгөөний өөрчлөлт хийх ажлын төлөвлөлт хийхдээ цахилгааны агаарын болон газар доорх шугам, шилэн кабель, ус, хий, тос, түлшний шугам хоолой зэрэг газар дээрх болон доорх байгууламж байгаа эсэхийг урьдчилан шалгаж тэдгээрийг төлөвлөгөөндөө бүрэн тусгана.

12.8.Төлөвлөлтийн инженер нь замын ажил хийх төлөвлөгөөнд газар дээрх болон доорх байгууламжуудын аюулгүйн зай, хэмжээг тодорхой тусгаж тэдгээрийг гэмтээхгүйгээр уг ажлыг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэн төлөвлөнө.

### **Арван гурав. Өөрчлөлтийг мэдээлэх үе шат**

13.1.Аливаа замын өөрчлөлт хийгдэх төлөвлөгөө гарсан даруй уурхайн бүх хэлтэс нэгжийн удирдлага болон ХАБ-ын ажилтанд мэдэгдэж төлөвлөлтийн зургийг хэвлэж уурхайн мэдээллийн самбаруудад байрлуулна.

13.2.Төлөвлөлтийн инженер нь төлөвлөлт хийхдээ зураг дээр замын хөдөлгөөний чиглэлийн өөрчлөлт хийх болон шинээр зам тавих хэсгийг “Улаан” өнгөөр дугуйлан хүрээлж тэмдэглэх бөгөөд замын хөдөлгөөний чиглэлийг “Хөх”, “Улаан” өнгөөр ялган тодорхой тэмдэглэнэ. Мөн уг төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх буюу мэдээллийн самбарт тавьсан өдрийг зургийн баруун дээд хэсэгт тод харагдахуйцаар “Улаан” өнгөөр бичиж тэмдэглэсэн байна.

13.3.Ажилтан ээлж хүлээн авах бүртээ аливаа замын хөдөлгөөний өөрчлөлт хийгдсэн мэдээлэл самбарт тавигдсан бол түүнтэй танилцах үүрэгтэй бөгөөд асуух тодруулах зүйл гарвал ээлжийн мастер болон ХАБ-ын ажилтанд хандана.

13.4.Уурхайн ажилтан хөдөлмөрийн дотоод журмын дагуу 14 хоногийн амралт болон тухайн жилийн ээлжийн амралтын дараа ажилтан ажилдаа ирж байгаа тохиолдолд уурхайн бүсэд хийгдсэн аливаа замын хөдөлгөөний өөрчлөлтийн талаар мастераас асууж лавлана.

### **Арван дөрөв. Өөрчлөлт хийх үе шат, хариуцлага**

14.1.Аливаа төлөвлөгдсөн өөрчлөлтийг хийх мастер нь тухайн ажлын талбайн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бөгөөд уг төлөвлөгөө энэхүү шаардлагад нийцэж байгаа эсэхийг газар дээр нь үнэлж шаардлагатай бол төлөвлөгөөнд дахин өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Энэ тохиолдолд уурхайн удирдлага болон ХАБ-ын ажилтанд мэдэгдэж чиглэл, зааварчилгаа авна.

14.2.Шинээр зам тавих тохиолдолд уг ажлыг удирдан хийлгэж байгаа мастер нь шинээр нээгдэх замын орох, гарах уулзварт журмын дагуу хангалттай өндөртэйгээр хаалт далан хийлгэж зөвшөөрөлгүй хөдөлгөөнийг бүрэн хаасан байх ажлыг гүйцэтгэнэ.

14.3.Замыг нээхийн өмнө төлөвлөгөөнд тусгасан ажлыг бүрэн гүйцэтгэх, шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг бүрэн хийлгэх ажлыг мастер хариуцан гүйцэтгэнэ.

14.4.Замын өөрчлөлт 1 ээлжийн хугацаанаас удаан үргэлжлэх бол өдөр бүрийн шуурхай хуралдаан дээр ажлын үе шатыг уулын мэдээнд оруулан тайлагнаж явна.

14.5.Мастер нь замын ажил хийх талбайн аюулгүй ажиллагааг хангах үүднээс шинээр замын ажил хийх бол тухайн замын ажил бүрэн дуусах хүртэл шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ тавигдсаны дараа уулзвар дээр тавьсан хаалт даланг авч замыг нээх бөгөөд замыг нээсэн гэдгээ ХАБ-ын ажилтан болон тухайн замын хэсгийг ашиглаж байгаа ажилтнуудад мэдээлсэн байна.



14.6. Уурхайн удирдах ажилтан аливаа замын хөдөлгөөний өөрчлөлтийн төлөвлөгөө болон гүйцэтгэх ажлын талаар өөрийн хариуцсан хэсэг нэгжийн ажилтнуудад цаг тухайд нь мэдэгдэж аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлээ.

14.7. Өөрчлөлт хийх ажлыг харицсан мастер (ажлын наряд өгсөн ажилтан) нь дор дурдсан үүрэгтэй.

14.7.1. Замын ажил хийхэд шимт хөрс хуулах бол "Газар хөндөх зөвшөөрөл" авагдсан эсэхийг шалгаж баталгаажуулах;

14.7.2. Замын ажил хийхээс өмнө төлөвлөгөөтэй танилцах явцдаа газар дээрх болон доорх байгууламж байгаа эсэхийг магадлан шалгах үүрэгтэй бөгөөд шаардлагатай бол мэргэжлийн ажилтны дүгнэлтийг бичгээр гаргуулж авах;

14.7.3. Тухайн замын өөрчлөлтийн ажлыг газар дээр нь аюулгүй зохион байгуулж шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч уурхайн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

14.7.4. Ажлын явцын тухай мэдээллийг удирдлагадаа болон ХАБ-ын ажилтанд цаг тухайд нь өгч байх бөгөөд зам нээх болон хаах тохиолдол бүрт дээрх ажилтнуудад заавал мэдэгдэнэ;

14.7.5. Газрын дээрх болон доорх байгууламж байгаа тохиолдолд газар дээр нь ажлын Аюулгүйн Шинжилгээ хийж тэдгээр байгууламжийг гэмтээхгүйгээр, ажлаа аюулгүй үргэлжлүүлэн зохион байгуулах;

14.7.6. Шинэ ээлж ирэх бүрт тухайн ээлжийн ажилтнуудад уурхайн бүсэд амралтын хугацаанд нь хийгдсэн замын хөдөлгөөний өөрчлөлтийг танилцуулах;

14.7.7. Ээлж солилцох бүртээ өөрийн ээлжинд хийгдсэн замын хөдөлгөөний өөрчлөлтийг дараагийн хүндээ заавал танилцуулж хүлээлцэх зэрэг болно.

14.8. Өөрчлөлт хийх ажлыг харицсан ХАБ-ын ажилтан дор дурдсан үүрэгтэй.

14.8.1. Замын хөдөлгөөний өөрчлөлттэй холбоотой аливаа мэдээллийг авсан даруй Онцгой байдлын болон Яаралтай тусламжийн нэгжийн ажилтнуудад мөн тухайн хэсэгт замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарт уг мэдээлэл хүрсэн эсэхийг шалгаж баталгаажуулах;

14.8.2. Шинээр тавигдсан замыг нээх тухай мэдээ авсан даруй тухайн замыг очиж шалган шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ журмын дагуу тавигдсан эсэхийг шалгаж шаардлагатай бол замыг нээх хугацааг хойшлуулах;

14.8.3. Ажлыг хойшлуулах бол төлөвлөлтийн инженер болон харилцан ажиллаж байгаа уулын мастертай ярилцаж шийдвэрлэх асуудал, гүйцэтгэх хугацааны талаар Олборлолтын болон ХАБ хариуцсан нэгжийн менежерт бичгээр мэдэгдэх;

14.8.4. Тухайн замын хэсгийн өөрчлөлтөд хамаарч байгаа гэрээт компанийн ажилтнууд уг өөрчлөлтийн талаар мэдээлэл авсан эсэхийг шалгаж баталгаажуулах;

14.8.5. Шаардлагатай тохиолдолд Аюулгүй ажиллагааны сургагчид мэдэгдэж хэрэгцээтэй сургалт, зааварчилгааг өөрийн болон гэрээт компанийн ажилтнуудад сургалтыг өгүүлэх зэрэг болно.

### Арван тав. Хамгаалалтын далан

15.1.Замын тусгаарлах далан, хамгаалалтын далан нь 1.5 м буюу тухайн замд зорчих хамгийн том тээврийн хэрэгслийн дугуйны өндрийн хагастай тэнцэх хэмжээтэй байна.

15.2.Уурхайн бүх нээлттэй мөргөцөг бүрийн ирмэг дагуу хамгаалалтын далан тавьсан байх шаардлагатай бөгөөд энэ нь ослын үед тухайн замаар зорчих техникийг бүрэн зогсоож чадахуйц хэмжээтэй байна. Хамгаалалтын далан тавих замын материал нь зохих шаардлага байвал зохино.

### Арван зургаа. Бусад

16.1.Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, "ЭТТ" ХК-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заагдсан хариуцлагыг хүлээлгэнэ.

--- оОо ---

### ХАВСРАЛТ №1: Паркын дугаарыг бичих загвар

Паркын дугаар хийх загварын томъёолол				
№	Овор хэмжээ, зориулалт	Код	Дугаар	Жишээ
1	Бага оврын суудлын машин	LV	***	LV 001-099 ЭТТ, LV 100-199 Зүүн уурхайн гэрээт LV 200-299 Баруун уурхайн гэрээт
2	Үйлчилгээний машин	SV	***	SV 001-099 ЭТТ, SV 100-199 Зүүн уурхайн гэрээт SV 200-299 Баруун уурхайн гэрээт

Паркын дугаар нь машины 2 талд хаалган дээр, мөн урд талд байрлуулна. Хар дэвсгэр дээр шар өнгөөр "ARIAL" фонтоор "BOLD"-оор бичсэн байна. Хар

өнгөний код 250, шар өнгөний код 503.

Үсгийн өндөр нь 180мм байхаар үсгийг шахаж байрлуулсан байна.

Паркын дугаарын дэвсгэр нь 240 х 750 мм хэмжээтэй байна.

Хүнд механизм дээрх тоог тухайн техникийн “хориотой бүс”-ийн гаднаас тод харагдахуйц хэмжээтэй хийнэ.

Дээд тал нь 2 үсэг + 3 тоо байна.

Хүнд механизмуудыг шууд тоогоор нь дугаарлана.

